

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭ

1. Гэрээ байгуулагч Талууд:

1.1. Нэг талаас: Төсвийн ерөнхийлөн захирагч
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
(албан тушаал, нэр)

ГОМБОДОРЖИЙН БАТСУУРЬ

(эцэг/эх/-ийн нэр, нэр)

1.2. Нөгөө талаас: Төсвийн шууд захирагч
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА
(албан тушаал)

НАМСРАЙН АЛТАНЦЭЦЭГ

(эцэг/эх/-ийн нэр, нэр)

бид дор дурдсан асуудлаар харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

2. Гэрээний агуулга, зорилго

2.1. "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас хэрэгжүүлэх хөтөлбөр, нийт арга хэмжээ, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-үүд болон бусад эрх үүргийг тусгав.

2.2. Энэхүү гэрээний зорилго нь үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зэрэг төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

НЭГ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

1. Төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг

1.1. Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 16 нийт арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ.

1.4. Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 2

Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт (шалгуур үзүүлэлт)	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам (өөрийгөө хөгжүүлэх чиглэл)	Хуанлийн хугацаа, хүн/өдөр
1	2	3
Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт -1: -Мэргэжлийн үр чадвараа дээшлүүлж, холбогдох сургалтанд үр дүнтэй хамрагдах	-Өөрийн мэргэжилтэй холбоотой зохион байгуулагдаж байгаа сургалт, семинарт тогтмол хамрагдах.	30 хүн/өдөр

1.5. Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажиллана

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг

2.1. Төсвийн шууд захирагчтай байгуулах гэрээнд тусгаж хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ нийт арга хэмжээнд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

2.2. Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллага хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай төсвийг эрх бүхий байгууллагаар батлуулна.

2.3. Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хугацаанд нь хийнэ.

2.4. Гэрээнд тусгагдсан хөтөлбөр, нийт арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь төсвийн шууд захирагчид байнгын дэмжлэг туслалцаа үзүүлж, гэрээний биелэлтийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5. ТТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

ХОЁР.БУСАД ЗҮЙЛ

3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана. Энэхүү гэрээний хугацаа сунгагдахгүй.

4. Гэрээ байгуулах болон дүгнэх хугацаа:

4.1. Гэрээг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаагаар байгуулав.

4.2. Төсвийн шууд захирагч гэрээний биелэлтийг хагас жилийг 2019 оны 06 дугаар сарын 10-ны дотор, жилийн эцсийн биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 01-ний дотор багтаан тайлагнаж, төсвийн ерөнхийлөн захирагч 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор, 2019 оны 12 дугаар 31-ний дотор багтаан түүний биелэлтийг дүгнэнэ.

5. Гэрээний урамшуулал ба хариуцлага

5.1. Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд түүнийг урамшуулах асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2. Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч түүнд туслалцаа дэмжлэг үзүүлэх, шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6. Гэрээ байгуулсан:

Төсвийн ерөнхийлөн захирагч

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
(албан тушаал)
Тэмдэг



/ Х. БАТСУУРЬ /

(огноо)

Төсвийн шууд захирагч
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА
(албан тушаал)
Тэмдэг



/ Н. АЛТАНЦЭЦЭГ /